



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 938

Улаанбаатар хот

### “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, 6.2.6, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 8 дугаар зүйлийн 8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инвескор актив ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах 24 сарын хугацаатай, жилийн 16.4%-ийн хүүтэй, нэг бүр 400,000 /дөрвөн зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 /арван мянга/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд түргэн шуурхай бүртгэж, анхдагч зах зээлийн бэлтгэл ажлыг хангахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасны анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Инвескор капитал ҮЦК” ХХК /Г.Уянгахишиг/-д мэдэгдсүгэй.

4. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцох хүртэл арилжаанаас олсон орлогыг тусгаарлахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

5. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжааны тайланг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл авахыг “Инвескор капитал ҮЦК” ХХК /Г.Уянгахишиг/-д үүрэг болгосугай.

6. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Долгорсүрэн/-т тус тус даалгасугай.

7. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссан өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хөрөнгийн багцад бүртгэлтэй хөдлөх хөрөнгөөр энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан транч А-д эзэмшиж буй хөрөнгө оруулагчдын үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжид хангуулахыг “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК /Б.Намуугэрэл/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Инвескор актив ТЗК” ХХК /Б.Хишигтөр/-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болохыг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь хөдлөх хөрөнгийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн дугаараар Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгүүлж, энэ талаар 4 сарын дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх.

9. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК /Б.Намуугэрэл/-д үүрэг болгосугай:

1/ Хороонд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;


2/ Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны урт хугацаатай өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

10. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв эсэхийг үнэт цаас гаргагч “Инвескор актив ТЗК” ХХК /Б.Хишигтөр/, хөрөнгө итгэмжлэн удирдагч “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК /Б.Намуугэрэл/, “Инвескор капитал ҮЦК” ХХК /Г.Уянгахишиг/-д болон энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий анхны үүрэг гүйцэтгүүлэгч 2 банк бус санхүүгийн байгууллага хариуцахыг дурдсугай.

11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГ  Д.БАЯРСАЙХАН


Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн  
9.38 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Инвескор актив ТЗК” ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Транч А	400,000	8,500	16.4%	24 хүртэл сар	3,400,000,000	85.0%
Транч Б	400,000	1,500	16.4%	24 хүртэл сар	600,000,000	15.0%
Нийт	-	10,000	-	-	4,000,000,000	100.0%

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн  
98 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Инвескор актив ТЗК” ХХК-д авто машины зээл багцлан 9020030255 5043239  
худалдаж буй анхны үүрэг гүйцэтгүүлэгчид

№	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөгөөр/	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ
1	“Инвескор ББСБ” ХК	3,000,000,000	75.0%
2	“Микрокредит ББСБ” ХХК	1,000,000,000	25.0%
Нийт		4,000,000,000	100.0%